



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 13 өдөр

Дугаар

A/87

Улаанбаатар хот

Захирамжид өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.8, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 30.2, Иргэд төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хянаж шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйл 15.3, Захиргааны ерөнхий хуулийн 27 дугаар зүйл 27.2.1, 27.5, 27.6 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/847, 2024 оны А/219 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн Засаг даргын 2024 оны А/244 дүгээр захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгийн 2025 оны 03 дугаар хурлын тэмдэглэл, Чингэлтэй дүүргийн Цагдаагийн газрын 2025 оны 30л-1/432 дугаар албан бичиг болон иргэдээс ирүүлсэн гомдлын дагуу сонсох ажиллагаа явуулсан тул Дүүргийн Засаг даргын 2024 оны А/290 дүгээр захирамжийн 2 дугаар хавсралтын "Трий трэй шүрс" ХХК-д холбогдох хэсгийн 14:00-04:00 цаг гэснийг 14:00-22:00 цаг гэж, 2024 оны А/379 дүгээр захирамжийн 2 дугаар хавсралтын "Би энд эм эл" ХХК-д холбогдох хэсгийн 14:00-04:00 цаг гэснийг 14:00-00:00 цаг гэж тус тус өөрчлөлт оруулсугай.

2. Согтууруулах ундааг худалдаалах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгогдсон хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс (М.Навчаа), Чингэлтэй дүүргийн Цагдаагийн газар (Ц.Амгалан-Энх), дүүргийн 5-6 дугаар хорооны Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Үнэт цаасны бичилт, олголт, хураамжид байнгын хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Энхбаяр), захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (З.Бямбажав)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.МАНДУУЛ

1525010287